

Мөнгөний тойм

2009 оны 4 дүгээр сар

1. Үнэ

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2009 оны 4 дүгээр сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх сартай харьцуулахад 2.2%, оны эхнээс 5.5%, өмнөх оны мөн үеэс 12.5%, Улаанбаатар хотын хэмжээнд өмнөх сараас 1.9%, оны эхнээс 4.7%, өмнөх оны мөн үеэс 12.6%-иар тус тус өссөн байна. Хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцсон суурь инфляци өмнөх сараас 0.5%-иар нэмэгджээ.

Хүснэгт 1. Хэрэглээний барааны үнийн индекс /хувиар/


	Хувийн жин	2009-IV 2008-IV	2009-IV 2008-XII	2009-IV 2009-III
Хүнсний бараа, ундаа, ус	41.08	107.4	112.1	104.7
Согтууруулах ундаа, тамхи	2.26	115.1	111.4	101.6
Хувцас, бөс бараа, гутал	12.38	120.3	97.8	99.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.40	111.4	93.3	96.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.30	111.1	104.4	101.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.62	109.8	101.8	100.7
Тээвэр	8.71	125.1	96.4	98.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.05	103.4	107.5	107.8
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.33	105.2	101.5	100.8
Боловсролын үйлчилгээ	4.15	137.6	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.72	130.1	103.4	101.0
Бусад бараа үйлчилгээ	3.0	118.3	106.7	101.1
Ерөнхий индекс	100.0	112.6	104.7	101.9

Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо, (Улаанбаатар хотын индекс)

Хэрэглээний үнийн индексээр тооцсон сарын инфляци Улаанбаатар хотод 2009 оны 4 дүгээр сард 1.9%-иар өссөн нь хэрэглээний барааны сагсанд өндөр хувийн жин (41.1%) эзэлдэг хүнсний бараа, ундаа, ус бүлгийн дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант сард хувцас, бөс бараа, гутал, орон сууц, ус, цахилгаан, түлш, тээвэр бүлгүүдийн дүн 0.1%-3.1%-иар буурч, бусад бүлгүүдийн дүн 0.7%-7.8%-иар өсчээ. Харин боловсролын үйлчилгээ бүлгийн дүн тогтвортой байлаа.

Зураг 1. Инфляци



Хүнсний бараа, ундаа, ус бүлгийн дүн 4.7%-иар өссөнд хонины махны үнэ (1 кг) 13.6%, үхрийн махных 2.4%, байцааных 29.0%, элсэн чихрийнх 16.5%, цагаан будааных 9.0 %-иар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Мөн валютын ханшийн өөрчлөлттэй холбогдон дотоодын болон гадаад руу утсаар ярих тариф 3.5%-20%-иар өссөн нь холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн дүн 7.8%-иар өсөхөд хүргэжээ.

Орон сууц, ус, цахилгаан, түлш бүлгийн дүн 3.1%-иар буурсан нь орон сууц түрээслэх үнэ 2.0%, түлшний модны үнэ (1 шуудай) 12.1%, нүүрснийх (1 шуудай) 13.4%-иар буурснаас шалтгаалжээ. Бензин (А-80, 1 литр)-ийн үнэ 1.0%, бензин (А-93)-ийх 2.6%, дизелийн түлшнийх 3.7%-иар тус тус буурсан нь тээвэр бүлгийн дүн 2.7%-иар буурахад нөлөөлсөн байна.

2. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт¹ өмнөх оны мөн үеэс 2.7% буюу 66.1 тэрбум төгрөг, өмнөх сараас 0.5% буюу 12.7 тэрбум төгрөгөөр тус тус буурч 2400.6 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард бараг мөнгө 0.9% буюу 17.3 тэрбум төгрөгөөр багассан нь нийт мөнгөний бууралтад нөлөөлжээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд 2008 оны мөн үеийнхээс 33.6 нэгжээр саарсан байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 3.3% буюу 11.5 тэрбум төгрөг, өмнөх сараас 5.1% буюу 17.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 355.6 тэрбум төгрөгт хүрчээ.

2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг эх үүсвэр талаас нь авч үзвэл, бараг мөнгө² 77.4 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 55.5%, гадаад валютын хадгаламж 26.5%, гадаад валютын харилцах 18.0 %), бага мөнгө³ буюу М1 мөнгө 22.6 хувийг (үүнд банкнаас гадуурх мөнгө 53.1%, төгрөгийн харилцах 46.9 %) тус тус бүрдүүлж байна.

Бараг мөнгө

Бараг мөнгө нь тайлант сарын эцэст 1858.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 0.9% буюу 17.3 тэрбум төгрөгөөр багассан нь гадаад валютын хадгаламж 35.1 тэрбум төгрөг, валютын харилцах 13.4 тэрбум төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ. Бараг мөнгөний өсөлт 2008 оны мөн үеэс 33.1 нэгжээр саарчээ.


¹ М2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, М1 мөнгөний нийлбэр.

² Бараг мөнгө нь төгрөг болон валютын хадгаламж, валютын харилцах данс, хадгаламжийн сертификатаас бүрдэнэ.

³ М1 мөнгө нь банкнаас гадуурх мөнгө, банкуудын төгрөгийн харилцах данснаас бүрдэнэ.

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 0.2% буюу 2.7 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 0.3% хувь буюу 3.9 тэрбум төгрөгөөр бууран 1524.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 2. M1, M2, Бараг мөнгө (жилийн өөрчлөлт)



Нийт хадгаламжийн 67.7 хувь нь төгрөгийнх, 32.3 хувь нь валютын хадгаламж байна. Тайлант сард төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 5.4% буюу 58.6 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх сараас 3.1% буюу 31.2 тэрбум төгрөгөөр өсч 1032.6 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх оны мөн үеэс 14.2% буюу 61.3 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 6.7% буюу 35.1 тэрбум төгрөгөөр буурч 491.7 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 3. Нийт хадгаламж /жилийн өсөлт/



Мөн гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс 7.4% буюу 26.8 тэрбум төгрөг, өмнөх сараас 3.9% буюу 13.4 тэрбум төгрөгөөр буурч 334.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Бага мөнгө

Бага мөнгө (M1) өмнөх оны мөн үеэс 7.2% буюу 41.9 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх сараас 0.9% буюу 4.6 тэрбум төгрөгөөр өсч 541.7 тэрбум төгрөг болов. Тайлант сард банкнаас гадуурх мөнгө 15.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь бага мөнгөний өсөлтөд нөлөөлжээ. Бага мөнгөний өсөлтийн хурд 2008 оны мөн үеийнхээс 35.4 нэгжээр саарсан байна.

Тайлант сард төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 18.1% буюу 56.1 тэрбум төгрөг, өмнөх сараас 4.0% буюу 10.4 тэрбум төгрөгөөр тус тус буурч 254.0 тэрбум төгрөгт хүрчээ.

Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 80.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх сараас 0.3 нэгж, өнгөрсөн оны мөн үеэс 1.4 нэгжээр их байлаа. Мөн банкнаас гадуурх мөнгө M2-ийн харьцаа 12.0 хувь болсон нь өмнөх сараас 0.7 нэгж, өнгөрсөн оны мөн үеэс 0.9 нэгжээр их байна.


2.2 Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 9.6% буюу 46.7 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 8.8% буюу 51.7 тэрбум төгрөгөөр бууран 536.1 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард банкуудын харилцах, хадгаламж 69.0 тэрбум төгрөгөөр багассан нь нөөц мөнгийг бууруулжээ.

2.3 Гадаад, дотоод цэвэр актив

Тайлант сард гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 42.1% буюу 527.5 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх сараас 5.4% буюу 37.0 тэрбум төгрөгөөр өсч 725.9 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх оны мөн үеэс 38.0% буюу 461.4 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 2.9% буюу 49.7 тэрбум төгрөгөөр буурч 1674.7 тэрбум төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 30.2 хувь нь гадаад цэвэр активт, 69.8 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Зураг 4. Гадаад, дотоод цэвэр актив




Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц 2009 оны 4 дүгээр сарын байдлаар 538.0

сая ам. доллар байж, импортын 17.2 долоо хоног буюу 4.3 сарын төлбөртэй дүйцэхүйц байна. Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 45.9% буюу 456.7 сая ам.доллараар буурч, өмнөх сараас 6.7% буюу 33.9 сая ам.доллараар өсчээ.

Зураг 5. Гадаад валютын цэвэр албан нөөц, сая ам. доллар



Зээл

Дотоод цэвэр активын гол бүрэлдэхүүн болох банкны салбараас олгосон зээл тайлант сарын эцэст 2580.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 143.7 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 91.5 тэрбум төгрөгөөр буурчээ. Банкуудаас хувийн хэвшилд олгосон зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.5%-иар өсч 1621.9 тэрбум төгрөгт, улсын салбарт олгосон зээл 0.1%-иар өсч 22.4 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл 9.9%-иар буурч 930.6 тэрбум төгрөгт, бусад


байгууллагад олгосон зээл 77.5%-иар буурч 5.4 тэрбум төгрөгт тус тус хүрэв. Зээлийн өрийн үлдэгдлийн өсөлтийн хурд 2008 оны мөн үеийнхээс 59.0 нэгжээр саарсан байна.

Хүснэгт 2. Зээл, зээлийн хүү /жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, тэрбум төгрөг/

	2006	2007	2008	2009
Зээл	981,79	1477,61	2436,53	2580,24
жилийн өөрчлөлт (%)	48,7	50,5	64,9	5,9
Төгрөгийн зээлийн хүү	29,5	25,3	17,3	19,9
жилийн өөрчлөлт (нэгж)	(4,0)	(5,0)	(0,6)	(2,3)
Валютын зээлийн хүү	16,2	16,3	13,9	19,9
жилийн өөрчлөлт (нэгж)	-0,7	0,1	-2,4	6,0

Нийт зээлийн үлдэгдлийн 83.4 хувийг хэвийн зээл, 6.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 10.6 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин өнгөрсөн оны мөн үеэс 7.9 нэгжээр өсчээ.

Зураг 6. Зээлийн өрийн үлдэгдэл



Харин өмчлөгчөөр нь авч үзвэл нийт зээлийн 62.9 хувь нь хувийн хэвшил, 36.1 хувь нь иргэд, 0.9 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна. ХААН, Худалдаа хөгжил, Голомт банкууд нийт зээлийн 56.2 хувийг олгожээ.

Зээлийн хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 2.6 нэгж, өмнөх сараас 2.6 нэгжээр өсч жилийн 16.14 хувь болов. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү тайлант сард 15.75 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 2.2 нэгжээр нэмэгдсэн байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү⁴ өмнөх сарынхаас 0.9 нэгж, өмнөх оны мөн үеэс 2.3 нэгжээр буурч жилийн 19.5 хувьд, валютынх өмнөх сарынхаас 0.5 нэгж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.0 нэгжээр өсч жилийн 19.9 хувьд хүрчээ. Тайлант сард банкуудаас төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 6.0-29.8 хувь, валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 9.9-24.0 хувийн хооронд хэлбэлзэж байв.

⁴ Зарласан хүү

3. Мөнгөний зах зээл

Тайлант сард банк хоорондын захын арилжаагаар нийт 376.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 36.9 хувь нь овернайт зээл, 37.7 хувь нь банк хоорондын хадгаламж, 12.4 хувь нь банк хоорондын захаар олгосон зээл, 4.2 хувь нь Төв банкны үнэт цаас, 8.8 хувь нь репо хэлцлээр хийгдсэн арилжаа байна. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 15.75 хувь байлаа.

2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2009 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөнд 75.5 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөнд 57.1 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөнд 95.5 тэрбум төгрөг, валютын нөөцөнд 143.1 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

4. Валютын ханш

Төгрөгийн америк доллартай харьцах ханш 2009 оны 4 дүгээр сарын эцэст 1423.9 төгрөг болж, өмнөх сарынхаас 100 төгрөг буюу 6.6%-иар чангарч, өмнөх оны мөн үеэс 259 төгрөг буюу 22.2%-иар суларчээ.

Онцлох сэдэв:

Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайлан

2009 оны 1 дүгээр улиралд нийт 44 мянган иргэн, аж ахуйн нэгжид жижиг, дунд үйлдвэр эрхлэх зориулалтаар 48.6 тэрбум төгрөгийн зээл олгож зээлийн өрийн үлдэгдэл нь 465.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс 56.6 хувь буюу 263.5 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэдийн, 43.4 хувь буюу 201.9 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэл байна. Тухайн хугацаанд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хамгийн өндөр хүү жилийн 48 хувь, хамгийн бага хүү жилийн 7.5 хувь байна.

Хүснэгт 1. ЖДҮ эрхлэгчдийн зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧ	2008-IV	2009-I	2009-I
	дүн	дүн	2008-IV
Иргэд	291.7	263.5	-9.7%
Аж ахуйн нэгж	212.9	201.9	-5.2%
Бүгд	504.6	465.4	-7.8%

Ипотекийн зээлийн тайлан

Банкууд ипотекийн зээлийг өөрийн эх үүсвэр, Азийн Хөгжлийн Банк болон Орон сууцны санхүүжилтийн корпораци (ОССК)-ийн 40000 айлын орон сууцны төслийн эх үүсвэрээс олгосон байна. 2009 оны 3 дугаар сарын байдлаар нийт ипотекийн зээлийн өрийн үлдэгдлийн 69.4 хувийг өөрийн эх үүсвэрээс олгосон төгрөгийн зээл, 5.6 хувийг АХБ-ны эх үүсвэрээс олгосон зээл, 2.9 хувийг ОССК-ийн зээл, 22.1 хувийг өөрийн эх үүсвэрээс олгосон валютын зээл тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд нийт ипотекийн зээлийн дийлэнх хэсэг буюу 91.5 хувийг банкууд өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлж байна.

Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 3-р сарын эцэст 220.6 тэрбум төгрөг, үүнээс 2.3 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байна. Ипотекийн нийт зээлдэгчдийн тоо 16251 болжээ.

МОНГОЛБАНК